

ЗДТГ-ЫН ДАРГА

БАТЛОВ

СЭДЭГЭРЖАРГАЛ

2026 оны 05 дугаар сарын 09 өдөр

1919100026.5 9022732

Дархан-Уул аймгийн Орхон сумын Авлигын эсрэг шударга байдлын үнэлгээ сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө

2026.05.09


Орхон

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд улирал тутам дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг байршуулж хэвшүүлэх;	2026.05.09- 2026.12.01	Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан
2	Байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, иргэд олноор цугласан газарт очиж, олон нийтэд сурталчлах, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
3	Байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан эерэг бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	2026.05.09- 2026.12.01	Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан
4	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх,	2026.05.09- 2026.12.01	Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан
5	Иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
6	Иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	2026.05.09- 2026.12.01	Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан
7	Албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг тусгайлан зохион байгуулах	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

8	Сумын төсөвт байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээнд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнгээс хамаарах арга хэмжээ зохион байгуулах;	2026.05.09- 2026.12.01	Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан
9	Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал асуулга авч, түүний үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авах;	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
10	Албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
11	Удирдлагын зүгээс авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлж, олон нийтэд энэ тухай мэдээлэх;	2026.05.09- 2026.12.01	Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн
12	Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-т заасныг хэрэгжүүлэх хүрээнд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг баталж, хэрэгжүүлэх;	2026.05.09- 2026.12.01	Хяналт шинжилгээ үнэлгээний баг

Төлөвлөгөө гаргасан:

ХНХШҮХАжилтан



А.Болорчимэг